

Нүүрсэн дэх байгалийн цацраг идэвхт изотопуудын зөвшөөрөгдөх хэмжээг тогтоох асуудалд

Н.Норов, С.Даваа

(МУИС, Цөмийн физикийн судалгааны төв)

Establishing Limits of Natural
Radioactive Isotopes in Coal

Abstract. This paper provides a basic consideration of concepts and mathematical model for setting limits of natural radioactive isotopes in coal, using national safety standards.

1. Оршил

Эрчим хүчний төрөл бүрийн төхөөрөмжид нүүрс шатаасантай холбоотой үүсэх цацрагийн үйлчлэлд өртсен хүмүүсийн тоог тэдний авсан дундаж тунгаар үргүүлж гарах хамтын тун нь цөмийн түлшний циклээс авах (Чернобылийн ослыг тооцсон) тунгаас олон дахин их бөгөөд түүний хэмжээ дэлхийн нийт хүн амын хувьд 100 мянган хүн/Зв/жил орчим байна [1]. Нүүрс шатааснаас нийт үүн амын авах цацрагийн тун ийм их байгаа нь нүүрс ашиглах үед цацрагийн шарлагад өртөх хүн амын тоо олон байгаагаар тайлбарлагдана. Олборлож байгаа нүүрсэнд байгалийн цацраг идэвхт изотопууд (^{238}U , ^{232}Th)-ын агууламжийн дэвсгэр түвшин 10-50 Бк/кг байхад хувийн эффектив тун 0.1 мкЗв/жил-ээс хэтэрдэггүй байна.

Манай улсын эрчим хүчний хангамжийн 90 гаруй хувийг нүүрс түлж хангадаг бөгөөд Адуунчлуун, Багануур зэрэг хүрэн нүүрсний нилээд орд газрын нүүрсэнд ураны агууламж өндөр байгааг тогтоосон юм [2]. Иймээс манай улсад батлагдан мөрдөж байгаа улсын стандарт [3]-т заасан хүн амын авч болох цацрагийн нэмэлт тунгийн хэмжээ болон цацрагийн аюулгүйн норм ЦАН-83-д заасан барилгын материал дахь байгалийн цацраг идэвхт изотопуудын хувийн идэвхийн зөвшөөрөгдөх хэмжээг ашиглан эрчим хүч, ахуйн хэрэглээний нүүрсэн дэх байгалийн цацраг идэвхт изотопуудын зөвшөөрөгдөх хэмжээг үнэлэх аргачлалыг боловсруулсан тухай энд өгүүлнэ.

2. Нүүрс шатааснаас гадаад орчинд үүсэх
цацраг идэвхт бохирдолыг тооцох

Хүн амын авах цацрагийн тунг тооцох болон эрчим хүч, ахуйн хэрэгцээнд хэрэглэж байгаа нүүрсэн дэх байгалийн цацраг идэвхт изотопуудын зөвшөөрөгдөх хэмжээг тогтооход зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай цацрагийн нөлөөний үндсэн хүчин зүйлүүд нь:

А. Яндангийн утааны үнсээс агаарт хаягдах цацраг идэвхт изотопууд хүний биед амьсгалаар орохоос гадна тэдгээр нь газрын хөрсөнд бууж гамма цацрагийн гадаад шарлага үүсгэх;

Б. Бордоо болгон ашигласан үнс болон агаар мандлаас хөдөө аж ахуйн эзлэлбэр газрын хөрсөнд сууж үлдсэн дэгдэмтгий үнснээс хүнс тэжээлээр байгалийн цацраг идэвхт изотопууд хүний биед орох;

В. Цахилгаан станц, уурын зуухны үнсийг барилгын материал болгон ашиглах үед байгалийн цацраг идэвхт изотопуудын гамма цацрагийн гадаад болон байранд хуримтлагдсан радионы дотоод шарлага үүсэх зэрэг болно.

А.Цахилгаан станц, уурын болон гэрийн зуухнаас жилд агаар мандалд хаягдах идэвх A_o (Бк) хүн амын оршин суух S (m^2) талбайтай нутаг дэвсгэрт жигд тархсан гэж үзье. Тэгвэл газрын гадаргын идэвхийн дундаж нягт- ΔC_s

$$\Delta C_s = A_o / S \text{ болно (1).}$$

Идэвхийн жилийн интеграл агууламж:

$$\bar{C} = \frac{A_o}{V_{cuyx} \cdot S}; (2)$$

болно.

Үүнд: V_{cuyx} – суух хурд, дунджаар 0.01 м/с-тэй тэнцүү [1].

Илэрхийлэл (2) нь радон, түүний задралын бүтээгдэхүүнүүдэс бусад яндангийн утаатай хаягдах бүх байгалийн цацраг идэвхт изотопуудаас өгөх тунг тооцох боломжийг олгоно.

Газрын гадарга орчмын агаарт яндангийн утаатай хаягдаж тархсан радионы цацраг идэвхийн тэнцвэрт эзэлхүүний интеграл идэвх РЭА_{Rn}(Бк·с/m³)-ийг дараах томъёогоор тооцно [1]

$$\overline{P\mathcal{E}A}_{Rn} = \frac{A_o^{Rn} P\mathcal{E}A_{Rn}^{dun}}{S \cdot \sigma_{dun}}; (3)$$

Үүнд: S - хүн амын оршин суух талбай (m^2);

$P\mathcal{E}A_{Rn}^{dun}$ - газрын хөрс орчмын агаар дахь радионы задралын бүтээгдэхүүнүүдийн эквивалент агууламжийн дундаж утга (Бк·с/m³);

A_o^{Rn} – агаар мандалд хаягдах радионы идэвх;

$\sigma_{dun} = 0.02$ Бк/m² газрын гадаргын нэгж талбайгаас гарах радионы байгалийн гаралтын дундаж хурд.

Тороны задралаас үүдэх цацрагийн тунг радионы задралын бүтээгдэхүүнээс өгөх тунгийн хэмжээнээс 1000 дахин бага учир тороны хаягдлын нэлэөг тооцохгүй байж болно [1]. Яндагийн утаанаас хөрсний давхаргад сууж үлдсэн цацраг идэвхт изотопын хувийн идэвх $C_{хөрс}$ -ийг дараах томъёогоор тооцно.

$$C_{хөрс}^{хаяг} = \frac{A_o \cdot \tau}{S \cdot hs}; (4)$$

Б.Зуухны үнсийг бордоонд ашигласнаар хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хөрсөнд бий болох цацраг идэвхт изотопын хувийн идэвх:

$$C_{\text{хөрс}}^{\text{үнс}} = \frac{A_{\text{үнс}}^{\text{бор}} \cdot \tau}{S_{\text{Х.А.А.}} \cdot S \cdot h_s}; \quad (5)$$

Үүнд: $C_{\text{хөрс}}$ – бордоонд хэрэглэх зуухны үнсэн дэх цацраг идэвхт изотопуудын идэвх (Бк/жил);

τ - хөрсний давхарга дахь үдаан наст цацраг идэвх изотопуудын ургамалд орохгүй болтлоо амьдрах дундаж хугацаа ($\tau=100$ жил);

$S_{\text{Х.А.А.}}$ -хүн амын амьдарч байгаа нийт нутаг дэвсгэрт хөдөө аж ахуйн эдэлбэр газрын эзлэх хувь (харыцангүй нэгж); h_s -нэгж талбай дахь массын нэгжээр илэрхийлэгдсэн хөрсний давхаргын зузаан ($h_s=500$ кг/ m^2).

Яндангийн утаатай агаар мандалд хаягдсан цацраг идэвхт изотопуудаас амьсгалын замаар авах шарлагын тун [1,7]

$$X_{\text{хаяг}} = q(\bar{C}_U K^U + \bar{C}_{Th} K^{Th} + \bar{P}\bar{E} A_{Rn} K^{Rn}) \quad (6)$$

Үүнд: \bar{C} , $\bar{P}\bar{E}A$ -газрын гадарга орчмын агаар дахь ^{235}U , ^{232}Th , ^{222}Rn -ын интеграл агууламж (Бк/ m^3)-ийг илэрхийлэл (2), (3)-аар тооцено; q -насанд хүрсэн хүний амьсгалах хурд ($q=2,3 \cdot 10^{-4} \text{ m}^3/\text{s}$);

К-Нүүрс шатаах үед агаар мандалд хаягдах байгалийн цацраг идэвхт изотопуудаар амьсгалах нэгж идэвхт ноогдох цацрагийн тун (мкЗв/Бк)

Хөрсөнд суусан байгалийн цацраг идэвхт изотопуудаас цацрах гамма цацрагийн гадаад шарлагын тунгийн чадлын хэмжээг 2π "геометр"- ээр тооцоход дараах илэрхийлэл гарчээ [5].

$$P_v^{\text{хөрс}} = 0.052 \left[C_{Ra-226}^{\text{хаяг}} + C_{Ra-226}^{\text{үнс}} + 1.31 \left(C_{Th-232}^{\text{хаяг}} + C_{Th-232}^{\text{үнс}} \right) + 0.085 \left(C_{K-40}^{\text{хаяг}} + C_{K-40}^{\text{үнс}} \right) \right] \quad (7)$$

Хөрсөнд суусан хаягдаас үүсэх гамма цацрагийн гадаад шарлагын нэмэгдэл тун:

$$X_{\gamma}^{\text{хөрс}} = K_{\gamma} T P_{\gamma}^{\text{хөрс}} \quad (8)$$

Үүнд: T -шарах хугацаа ($T=8760$ цаг)

K_{γ} - гамма цацрагийн агаарт шингээгдсэн тунг өквивалент тунд шилжүүлэх коэффициент ($K_{\gamma}=0,72 \cdot 10^{-2}$ мкЗв/мкР) [1,7].

Жилд авах дотоод шарлагын тун:

$$D_{\text{дотоод}}^{\text{хэрс}} = \sum_i \left(C_{\text{хэрс},i}^{\text{хаяг}} + C_{\text{хэрс},i}^{\text{үнс}} \right) \cdot k_i$$

Үүнд: $C_{\text{хэрс}}$ – хэрсэн дэх цацраг идэвхт изотопуудын хувийн идэвх
(Бк/кг)-ийг илэрхийлэл (4), (5)-аар тооцно;

k_i – цацраг идэвхт изотопуудын идэвхийг жилд авах тунд шилжүүлэх тунгийн коэффициентын утга [1].

- Хүн амын амьдрах нэгж талбайд жилийн турш хаягдах нийлбэр идэвхийг
- Нэгж талбайд оногдох зуухны тоо – $N_s(\text{м}^2)$;
- Нэг зууханд түлэх нүүрсний хэмжээ – $M (\text{кг})$;
- Зуухнаас гарах үнсний нийт хэмжээнд дэгдэхмий үнсний эзлэх хувь – ε (харьцаангуй нэгж);
- Зуухны нийт үнснээс газар тариаланд ашиглах хувь - η (харьцаангуй нэгж) гэх мэт параметрүүдээр илэрхийлбэл:

$$\frac{A_{\text{дт}}}{S} = C_i M N_s \varepsilon \cdot \mu_i; (10)$$

$$\frac{A_{\text{хэрс},i}}{S} = C_i M N_s (1 - \varepsilon \mu_i) \eta; (11)$$

болов бөгөөд илэрхийлэл (2)-оос газрын гадарга орчмын агаар дахь цацраг идэвхт изотопуудын эзэлхүүний жилийн интеграл идэвх:

$$\bar{C}_{\text{дт}} = \frac{C_i M N_s \varepsilon \mu_i}{V_{\text{сүүх}}}; (12)$$

болно.

Харин нүүрсийг шатаах үед радоны байгалийн бүрэн гаралт болохыг тооцвол (3)-р илэрхийллээр радоны РЭА-ыг дараах ёйдлаар тооцно.

$$\overline{\text{ЭРДА}}_{Rn} = \frac{C_{Rn} M N_s \overline{\text{ЭРДА}}_{Rn}^{\text{дунд}}}{\sigma_{\text{дун}}}; (13)$$

Яндангийн утаатай хаягдсан үнс хэрсөнд суух болон зуухны үнсийг бордоонд ашиглахад цацраг идэвхт изотопуудын хэрсэн дэх тэнцвэртэй агууламжийг (4), (5)-р томъёноос олблол:

$$C_{\text{хэрс}}^{\text{хаяг}} = \frac{C_i M_s N_s \varepsilon \mu_i \tau}{h_s}; (14)$$

$$C_{\text{хэрс}}^{\text{үнс}} = \frac{C_i M_s N_s (1 - \varepsilon \mu_i) \eta \tau}{S_{\text{x.a.s}} h_s}; (15)$$

болно.

Уран-238 ба түүний задралын Ra-226 хүртлэх бүтээгдэхүүнүүд, Ради-226, түүний задралын бүтээгдэхүүнүүд, Тори-232, түүний задралын бүтээгдэхүүнүүд, Кали-40-ийн хувьд тус бүрд нь (6)-(9)-ээр томъёонуудыг ашиглан цацрагийн тун D_{xy} -гийн илэрхийллийг гаргая. Цөмийн цацрагийн хүний организмд үйлчлэх бүх боломжийг тооцож, цацрагийн тунг цацраг идэвхтэй изотопуудын хувийн идэвх (1Бк/кг)-т харьцуулсан D_{xy} (мкЗв-кг/(Бк·жил)) байдалтай дараах илэрхийллүүд гарна.

$$D_{xy}^U = MN_s \left\{ \frac{q\mu \varepsilon k_{x_{\text{авн}}}^U}{V_{c,yk}} + \frac{k_{x_{\text{авс}}}^U \tau}{h_s} \left[\varepsilon \mu_U + \frac{\eta(1 - \varepsilon \mu_U)}{S_{x,a,a}} \right] \right\}; \quad (16)$$

$$D_{xy}^{Ra} = MN_s \left\{ \frac{q\varepsilon \mu_{Ra} k_{x_{\text{авн}}}^{Ra}}{V_{c,yk}} + \frac{\text{ЭРА}_{Ra}^{\text{дунд}} \cdot k_{x_{\text{авн}}}^{Ra}}{\sigma_{\text{дунд}}} + \frac{(0.052k_j T + k_{x_{\text{авс}}}^{Ra})\tau}{h_s} \left[\varepsilon \mu_{Ra} + \frac{\eta(1 - \varepsilon \mu_{Ra})}{S_{x,a,a}} \right] \right\}; \quad (17)$$

$$D_{xy}^{Th} = MN_s \left\{ \frac{q\varepsilon \mu_{Th} k_{x_{\text{авн}}}^{Th}}{V_{c,yk}} + \frac{(0.052 \cdot 1.31k_j \cdot T + k_{x_{\text{авс}}}^{Th})\tau}{h_s} \left[\varepsilon \mu_{Th} + \frac{\eta(1 - \varepsilon \mu_{Th})}{S_{x,a,a}} \right] \right\}; \quad (18)$$

$$D_{xy}^K = MN_s \left\{ \frac{0.052 \cdot 0.085k_j \cdot T \cdot \tau}{h_s} \left[\varepsilon \mu_K + \frac{\eta(1 - \varepsilon \mu_K)}{S_{x,a,a}} \right] \right\}; \quad (19)$$

M , N_s , η , $S_{x,a,a}$ параметрүүдийн тоон утга хот бүрийн оршин суугчдын хувьд ε өр ε өр байна. Цацраг идэвхтэй изотопуудын баяжих коэффициент (μ)-ын утга ураны хувьд 1.3, радиц-1.5, торид-1.2, кали-40-д-1.0-тэй тэнцүү байна. Зуухны нийт үнсэнд дэгдэмтгий үнсний эзлэх хувь $\varepsilon=0.5$ [7].

В.Зуухны үнсийг барилгын материал болгож ашиглахыг хязгаарлах цацрагийн хүчин зүйл нь түүний эффектив хувийн идэвх бөгөөд түүнийг дараах илэрхийллээр тооцно.

$$C_{\text{эфф}}^{\text{уч}} = \frac{1}{\beta(1 - \varepsilon)} [C_{Ra}(1 - \varepsilon \mu_{Ra}) + 1.31C_{Th}(1 - \varepsilon \mu_{Th}) + 0.085C_K(1 - \varepsilon)]; \quad (20)$$

Үүнд: β - нүүрсний үнслэг.

Дээр дурьдсан параметрүүдийн тоон утгыг (16)-(20)-д орлуулбал дараах илэрхийллүүд гарна.

$$D_{xy}^U = MN_s \left[1.18 + 0.10 \left(0.65 + 0.35 \frac{\eta}{S_{x,a,a}} \right) \right]; \quad (21)$$

$$D_{xy}^{Ra} = MN_s \left[1.26 + 1.67 \left(0.75 + 0.25 \frac{\eta}{S_{x,a,a}} \right) \right]; \quad (22)$$

$$D_{xy}^{\eta} = MN_s \left[4.17 + 4.94 \left(0.60 + 0.40 \frac{\eta}{S_{x,a,a}} \right) \right]; (23)$$

$$D_{xy}^K = MN_s \left[0.028 \left(1 + \frac{\eta}{S_{x,a,a}} \right) \right]; (24)$$

$$C_{\text{эфф}} = \frac{2}{\beta} [0.25C_{Ra} + 0.52C_{Th} + 0.04C_K]; (25)$$

Үүнд: C_{Ra} , C_{Th} , C_K – тулж байгаа нүүрсэн дэх ради-226, тори-232, кали-40-ийн хувийн идэвх (Бк/кг).

Хөрсний бүтцийг сайжруулахад ашиглах зуухны үнсний хувь хүн амын газар тариалан эрхэлж байгаа талбай ($S_{x,a,a}$)-тай шууд хамааралтай буюу хялбарчлахын тулд $\eta = S_{x,a,a}$ гэвэл хүн амын шарлагын жилийн тунг тооцох дараах илэрхийлэл гарна.

$$D = MN_s (1.3C_U + 3.0C_{Ra} + 9.1C_{Th} + 0.06C_K); (26)$$

Үүнд: C_U – түлэх нүүрсэн дэх уран-238-ын хувийн идэвх (Бк/кг).

Орон сууц болон албан барилгад зуухны үнсийг ашиглаж болох үнэлгээ нь ЦАН-83-д зааснаар:

$$C_{\text{эфф}} = 2/\beta (0.25C_{Ra} + 0.52C_{Th} + 0.04C_K) \leq 370 \text{Бк/кг} \text{ байх ёстой.}$$

Гэрийн болон уурын зууханд түлэх нүүрсэнд байгалийн цацраг идэвх элементүүдийн зөвшөөгдхөн хэмжээг үндэслэхэд илэрхийлэл (26)-ийг ашиглах бөгөөд хүн амын жилд авч болох нэмэгдэл тунгийн утга 1мЗв/жил-ээс хэтрэхгүй байх ёстой [3,4].

3. Үр дүн

Боловсуулсан энэ математик загвараар Улаанбаатар хотод эрчим хүч, ахуйн хэрэглээнд цацрагийн эрүүл ахуйн үүднээс ашиглаж болох Багануурын нүүрсэн дэх ураны зөшөөрөгдхөн хэмжээг тооцов.

Улаанбаатар хотод 3 сая тонн нүүрс жилд шатаадаг гурван цахилгаан станци, 180 мянган тонн, нүүрс хэрэглэх 140 гаруй уурын зуух, 60 орчим мянган гэрийн зуух байна [6]. Гэрийн нэг зууханд жилд 5 тонн нүүрс хэрэглэдэг ($M_r = 5000 \text{кг/жил}$) ба нэг уурын зууханд ($M_c = 1.3 \cdot 10^6 \text{ кг/жил}$), цахилгаан станциад ($M_e = 10^9 \text{кг/жил}$) нүүрс ноогдож байна.

Улаанбаатар хот ($30 \times 20 \text{ км}^2$)-д гэрийн болон уурын зуухны байрлах нягт $N_s^r = 1 \cdot 10^4 \text{ м}^2$; $N_s^c = 1.8 \cdot 10^{-7} \text{ м}^2$ болно. Цахилгаан станцын яндангийн өндөр 100-250 м, утас цэвэрлэх шүүлтуүрийн барих чадвар $\phi = 96\%$, Багануурын нүүрсний үнслэгийн дундаж утга $\beta = 14.9\%$ байдаг.

Станцаас утаатай гарах хаягдал 50 км радиустай талбайд тархана гэж үзэл ($N_s^e = 2.5 \cdot 10^9 \text{ м}^2$) болно. Эдгээр параметрүүдийн утгыг (25), (26)-д орлуулбал:

$$C_{\text{эфф}} = 3.4C_{Ra} + 7.0C_{Th} + 0.5C_K \leq 370 \text{Бк/кг} \quad (27)$$

$$D = 1.2C_U + 2.5C_{Ra} + 7.6C_{Th} + 0.05C_K \leq 1000 \quad (28)$$

Багануурын нүүрсэн дэх ^{232}Th -ийн хувийн идэвхийн дундаж утга 16 Бк/кг, ^{40}K -ийнх 67Бк/кг байгаа[2]-г ашиглан Улаанбаатар хотод түлэх Багануурын нүүрсэн дэх ураны зөвшөөрөгдхөх хувийн идэвхийг (28)-аар бодвол 240 Бк/кг (20 г/т), (27)-оор бодвол 146 Бк /кг (12 г/т) байна. Энэ нь цахилгаан станцын болон уурын зуухны үnsийг барилгын материал болгож ашиглах нөхцөлд Багануурын нүүрсэн дэх ураны зөвшөөрөгдхөх хэмжээ 12 г/т болохыг харуулж байна.

4. Дүгнэлт

1. Бидний боловсруулсан энэ аргачлалаар Улаанбаатар хотын эрчим хүч, ахуйн хэрэглээний нүүрсэн дэх ураны зөвшөөрөгдөх хэмжээ 20 г/т байна. Харин цахилгаан станц болон уурын зуухны үnsийг барилгын материал болгож ашиглах нөхцөлд Багануурын нүүрсэн дэх ураны зөвшөөрөгдөх хэмжээ 12 г/т болохыг тогтоо.

2. Нүүрсэн дэх цацраг идэвхт изотопуудын зөвшөөрөгдөх агууламжийг тогтоо энэ аргачлалын математик загварыг ашиглан цацраг идэвхт изотопуудын агууламж харьцангуй ихтэй нүүрсийг тухайн хот, суурин газрын ахуйн хэрэглээнд хүн ам, хүрээнд байгаа орчинд хор нөлөөгүй ашиглах асуудлыг шийдэх боломжтой юм.

Ашигласан хэвлэл

1. Sources, Effects and Risks of Ionizing Radiation.

Unitid Nations Scintific Committee on the Effects of Atomic Radiation,
Report of the General Assembly. New York, 1988.

2. Н.Норов, О.Отгонсүрэн, С.Даваа

Дорнод Монголын нүүрсний цацраг идэвхийг судалсан дүн.

МУИС. Эрдэм шинжилгээний бичиг. № 2 (125), 42-47-р хууд, УБ.1997 он.

3. УСТ-12.053.91 Цөмийн цацрагийн тунгийн хязгаар.

4. International basic safety standards for protection against ionizing radiation and for the safety of radiation sources (Safety series,ISSN 0,074-1892;115. Safety standerd), IAEA, Vienna.1996.

5. Крисюк Э.М. Радиационный фон помещения. М.: Энергоатомиздат. 1989.

6. Улаанбаатар хотын агаарын бохирдол.

(Онол-практикийн бага хурлын илтгэлүүд), хууд.132: УБ.1998

7. United Nations. Ionizing Radiation: Sourses, Effects and Biological Effects.

Unitid Nations Scintific Committee on the Effects of Atomic Radiation,
Report of the General Assembly. New York, 1982.